



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn


2022 10.13 № 01/13499
танай _____-ны № _____-т

┌ Хувийн ашиг сонирхлын урьдчилсан ┐
мэдүүлэг хянасан тухай

Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа “Боловсролын мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын захирлын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Цоодолын Нямхүүгийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Ц.Нямхүүгийн хамаарал бүхий этгээд болох төрсөн дүү Ц.Даваахүү нь мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээ, программ хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх “Битүүхээ” ХХК-ийн 100%-ийн хувьцаа эзэмшигч, захирлаар бүртгэлтэй байх тул тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж, хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА

1422003018391